

## ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр баталсан ИНЕГ-ын Захиргаа удирдлагын газрын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 09/20 дугаар удирдамжийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын Дотоод аудитын албаны аудитор П.Цогбаяр, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут, Б.Болормаа нар дотоод аудит, хяналт шалгалтыг хийсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан “Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх ажлын хүрээний харьяа байгууллагуудын 2019 оны үйл ажиллагааны тайлан хамгаалалтын үед гарсан саналыг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 4-т тусгагдсан “Бичиг баримтын хөтлөлт, хадгалалт хамгаалалтад анхаарч ажиллах, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн өргөдөл гомдлыг тухай бүрт нь шийдвэрлэж ажиллах.” гэсэн заалтын хэрэгжилтийг шалгалтын явцад хамруулан шалгалаа.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Захиргаа, удирдлагын газрын 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны баримт материалыг авч холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Ажилтнууд тушаалын төсөл боловсруулахдаа үг хэллэгийг зөв оновчтой хэрэглээгүй, ажилтныг гадаад орнуудад томилолтоор ажиллуулах, сургалтад хамруулах тухай тушаал гаргахдаа тухайн ажиллах болон суралцах улс, хот, байгууллагыг тодорхой заагаагүй, сургалтын болон томилолтын зардал, тээврийн зардлыг олгох эсэх нь тодорхойгүй, зарим тушаалууд үг үсгийн алдаатай боловсруулагдсан байна.

ИНЕГ-ын даргын тушаалын төслийг боловсруулсан болон хянасан, нийлсэн ажилтнууд “Баримт бичиг боловсруулсан тухай тэмдэглэлийн бүрдэл”-ийн талаар MNS 5140:2011 стандартад заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, боловсруулсан, хянасан, нийлсэн ажилтнууд гарын үсэг зураагүй байна.

2019 онд гадны байгууллага, иргэдэд явуулсан албан бичгийн байгууллагад үлдэх хувийн ар талын хэсэгт байх тэмдэглэгээнд боловсруулсан, хянасан ажилтны гарын үсгийг нэг ажилтан зурсан, мөн нэг ч ажилтан гарын үсэг зураагүй байх, үг үсгийн алдаатай байна. Ирсэн зарим албан бичгүүдэд удирдлагын чиглэл заалт, өгөөгүй, зөвхөн ажилтны нэр бичсэн, өгч байгаа үүргийн товч утга, хариуцан шийдвэрлэх ажилтны нэр, хэрэгжүүлэх хугацаа, цохолт хийсэн огноог бичээгүй, ирсэн бичгийн шийдвэрлэлтийн талаар тухайн асуудлыг хариуцсан ажилтнууд бүртгэл-хяналтын картанд тэмдэглэл хийгээгүй байна.

Агентлаг болон салбар нэгжүүд нь “Veritech ERP” програмын хүний нөөцийн зарим модулийг ашигладаггүй, ашиглаж байгаа модулийн хувьд мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, бүрэн гүйцэд оруулдаггүй, програмд мэдээллийг тогтмол оруулж, бүрэн ашиглах талаар уг ажлыг хариуцсан ажилтнууд санаа тавьж ажиллаагүйгээс програмын ашиглалт



хангалтгүй байна. Мөн уг програмын мэдээллийн иж бүрэн байдал, шинэчлэлт, ашиглалтын байдалд нэгдсэн байдлаар хяналт тавих ажлыг ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод зааж өгөөгүй.

Боловсон хүчин, хүний нөөцийн чиглэлээр гаргасан зарим тушаалуудад үндсэн үйл ажиллагааны чиглэлийн тушаал захирамжлалын “А” индекс өгсөн байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус газарт 6 зөвлөмж өгсөн болно.

## ДОТООД АУДИТЫН АЛБА